



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/22

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Соёлын яамнаас эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Олон угсаатны театрын барилга (Ховд, Жаргалант сум)-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Т.Дэлгэрсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүдэд: С.Мөнх-Очир - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Энхболд - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Ц.Цэцэгсүрэн - Иргэний төлөөлөл

Нарийн бичиг: Х.Дэмид - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Х.Дэмид)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

- 8400 03 0106
D/Tush-A/22-Bo